



**“ТЕФИС МАЙНИНГ” ХХК-ИЙН ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН
НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ЗҮҮН ХӨШӨӨТ”-ИЙН УУРХАЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2023**

Улаанбаатар хот 2023 он

Батлав:

БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын
Газрын дарга

..... Ц.Уранчимэг

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Тефис майнинг” ХХКомпанийн
Гүйцэтгэх захирал

..... Д.Чанцал

**“ТЕФИС МАЙНИНГ” ХХК-ИЙН ХОВД АЙМГИЙН ДАРВИ СУМЫН
НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ MV-012891, MV-012893 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ
“ЗҮҮН ХӨШӨӨТ”-ИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ2023**

Хянасан:

БОАЖЯ-ны БНБЗГ-ын ахлах шинжээч/Б.Жаргалнэмэх/

Боловсруулсан:

“Тефис майнинг” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн/Э.Гантулга/

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
1.1 Оршил.....	4
1.2 Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал.....	4
1.3 “Зүүн хөшөөт”-ийн нүүрсний ордын геологийн тогтоц.....	6
1.4 Уул уурхайн барилга байгууламж, машин техник.....	7
1.5 Ажиллах хүчний мэдээлэл	11
1.6 Уурхайн нүүрсний химийн лаборатори.....	12
1.7 Уулын ажлын ерөнхий мэдээлэл.....	13
1.8 2023 оны уулын ажлын төлөвлөгөө.....	14
2. БАЙГАЛЬ ОРЧИН ОРЧИН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛУУЛАГА	14
2.1 Уур амьсгал.....	15
2.2 Геоморфологи.....	15
2.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл.....	15
2.4 Усан хангамж.....	16
2.5 Хөрс.....	16
2.6 Ургамлан бүрхэвч.....	16
2.7 Нийгэм, эдийн засаг.....	17
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	17
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ.....	20
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ.....	21
6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
7. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
10. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	35
11. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	36
12. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	37
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	38
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ОРОЛЦООГ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВИАРЬ.....	39
15. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ.....	41
16. НЭМЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	42
17. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	43

1. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудын нэг юм.

“Тефис майнинг” ХХК нь улс орон болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нээлттэй ил тод байдал, тогтвортой хөгжлийг үнэт зүйлээрээ тодорхойлсон. Тиймээс байгаль орчны хамгааллын асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2023-2027 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 Байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Тус төлөвлөгөө Зүүн хөшөөтийн уурхайд хэрэгжүүлж байгаа нүүрс олборлохтой холбоотой бүх үйл ажиллагаанд хамаарахын хувьд “Тефис майнинг” ХХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад мөрдөгдөнө.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.

1.2 Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

“Тефис майнинг” ХХК нь Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт байрлах “Зүүн Хөшөөт”-ийн нүүрсний ордод олборлолтын үйл ажиллагааг явуулж байна. Тус орд нь Улаанбаатар хотоос баруун тийш 1272км, Ховд хотоос зүүн урагш 210 км-т, Дарви сумаас баруун урагш 60 км, Цэцэг сумаас хойш 30 км-т, Алтайн нурууны үргэлжлэл дээр оршино.

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь "Цагаан арын даваа" нэртэй MV-018291, (733.28 га); "Баатарын нуруу" нэртэй MV-018293, (353,39 га) буюу нийт 1086.67 га талбайд Төслийн талбайн солбицолын цэгүүдийн, байршлыг үзүүлэв.


Төслийн талбайн солибцол

Хүснэгт №1

д/д	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	93	20	47.35	46	48	11.50
2	93	20	47.35	46	48	07.08
3	93	20	54.14	46	48	07.08
4	93	20	54.14	46	48	02.07
5	93	21	04.92	46	48	02.07
6	93	21	04.92	46	47	57.54
7	93	21	26.75	46	47	57.54
8	93	21	26.75	46	47	53.02
9	93	21	39.82	46	47	53.02
10	93	21	39.82	46	47	56.89
11	93	21	48.61	46	47	56.89
12	93	21	48.61	46	47	53.30
13	93	21	59.56	46	47	53.30
14	93	21	59.56	46	46	40.00
15	93	19	39.55	46	46	40.00
16	93	19	39.55	46	47	31.49
17	93	19	54.55	46	47	31.49
18	93	19	54.55	46	48	11.50

Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн байршил

Зураг №1




“Дата Ресурс” ХХК-тай байгуулан Зүүн Хөшөөтийн уурхайн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.

1.3 “Зүүн Хөшөөт”-ийн ордын геологийн тогтоц

Хөшөөтийн чулуун нүүрсний орд, тухайн бүс нутагт геологийн түүхэн хөгжлийн явцад янз бүрийн гаралтай тунамал болон бялхмал хурдас тархсан байдаг бөгөөд тектоникийн бүс, дэд бүсүүдэд өөр өөрийн өвөрмөц шинж төрхийг хадгалан тогтсон байна. Хөшөөтийн ордын захын хэсгүүдийн геологийн тогтоц Хөшөөтийн нүүрст талбай нь “МоЭнКо” ХХК-ийн олборлолт явуулж байгаа Хөшөөтийн нүүрсний орд болон түүний захын хэсгүүдийг хамрана. Бидний олборлолт хийж байгаа хэсэг нь энэ ордын Зүүн хэсэг болно.

Зүүн хэсэг нь Хөшөөтийн ордын үндсэн синклинал зүүн жигүүрийн хэсгийг хамран байрладаг. Хөшөөтийн синклиналь структурын зүүн жигүүрт байрлах ба Хөшөөтийн ордын нэг хэсэг болно. Гадаргуу дээр ил аргаар олборлох үндсэн нүүрсний С ба В давхраас шууд үргэлжлэн зураглагдсан. Гадаргуу дээрээ нүүрсний гарш сайн боловч зарим үед уулын хажуу нь огцом тул хуурамч уналын өнцөгтэй байдаг. Сансарын зураг дээр тайлагдах байдал сайн. Зураглалыг 2006 онд явуулан 2010-2013 онуудад нэмэлт оруулсан байна.



Зураг №2. Зүүн Хөшөөтийн ордын геологийн зураг

Үндсэн синклиналь S1: Үндсэн синклиналь нь бүхэлдээ уг Хөшөөтийн уурхайн талбайн төв хэсэгт оршино. Зүүн хэсэгт уг үндсэн синклиналийн зүүн жигүүр талбайн хэмжээнд нийтдээ 1300 м унаж үргэлжилдэг. Гол тэнхлэг нь бараг урд зүгээс хойшоо чиглэсэн. Хоёр жигүүр нь ерөнхийдөө симметрлэг. Баруун жигүүрийн уналын өнцөг нь 40-60°. Харин зүүн жигүүрийн уналын өнцөг нь 70-85°. Синклиналийн зүүн жигүүр MV-018291 АТЗ-т талбайд хамаарна. Хайгуулын ДН0009, 10, 3 дугаар цооногуудад жигүүрийн чулуулаг нь өмнөөсөө хойш хөнтрүү байсан бол ДН00011, 002, 006, 007 цооногуудад синклиналийн жигүүр баруун, баруун хойш чиглэлд босоодуу, 75-85 градусаар унаж байгаа нь тогтоогдсон.



Зураг №3. А1 антиклиналийн тэнхлэг өмнө зүгээс хойд зүг харна.

F5 хагарлаар буюу Хөндлөнгийн жалгаар 2 блокт хуваагдсан бөгөөд өмнөд блок нь харьцангуйгаар 100 орчим м өргөгдөн байрласан тул илүү элэгдсэн бол, умард блок нь бага элэгдсэн байна. S1 синклиналь атираа гадаргууд их сайн илэрдэг. Уг синклиналь атираа нь олон тооны цооногуудаар батлагдсан. S1 синклиналь атирааны структурыг нилээд баттай судалж тогтоосон. Энэ структурын зүүн жигүүр нь А1 антиклиналийн баруун жигүүр болно.

1.4 Уурхайн барилга байгууламж, машин механизм

Зүүн Хөшөөт нүүрсний ордын уурхайд дараах барилга байгууламжууд байна. Үүнд:

- Уурхайн ажилчдын хотхон (20 ш гэр, Зөөврийн угсармал сууц, Уурын зуух, Лабортори, Авто граж)
- Уурхайн оффис (3-н зөөврийн сууц)
- Тэсрэх материалын агуулах (2 га)
- Нүүрс баяжуулах үйлдвэр
- Шатахуун нөөцлөх сав
- Авто засварын газар
- Гаалийн хяналтын талбай
- Бусад туслах материалын агуулах зэрэг орно.

Уурхайн оффис, ажиллагсдын байр: Уурхайн оффис, ажиллагсдын амрах байр болон хоолны заал, ажиллагсдын чөлөөт цагаа өнгөрүүлэх заал, сагсан бөмбөгийн талбай, теннисний ширээ зэрэг байрууд нь зөөврийн угсармал сууцууд байна. Уг байр нь галын болон агааржуулалтын сүүлийн үеийн технологи бүхий тоноглолоор бүрэн тоноглогдсон ажиллагсдын амрах тав тухыг бүрэн хангана.

Агуулах нь 20тн багтаамжтай, тэсэлгээний хэрэгсэлийн агуулахын багтаамж 250 хайрцаг хадгалах багтаамжтай юм. Тус агуулахыг “Пауэр Бласт” ХХК-ийн инженер техникийн ажилчид зохих стандарт зааврын дагуу барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгсөн. “Зүүн хөшөөт” төслийн тэсэлгээний агуулах тэсрэх бодисын хангалт тэсэлгээний ажлыг гэрээний түвшинд хэлэлцэж байна.



Зураг №4. Тэсэлгээний агуулах

Засварын төв: Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын цехэд хийж гүйцэтгэнэ. Засварын цех нь гар ялгалтын хэсгийн дэргэд байрлана. Засварын цехэд дугуй засвар, гагнуур, кран, компрессорын станц, кран тайл, токер, зэргийг байгуулсан. Уурхай, боловсруулах хэсгийн төхөөрөмжүүд, технологийн автомашин, үйлчилгээний автомашин зэргийг засварлах болно. Засварын цех нь 12 м урт, 10 м өргөн, 6 м өндөр байгууламж байх ба сендвичээр барьж байгуулсан. Засварын цех нь дотроо механик инженерүүдийн өрөө, засварчдын хувцас солих өрөө, ажлын өрөө, сэлбэг материалын агуулах, тос тосолгооны хэрэгслийг агуулах зэргийг багтаасан 20 тонн зөөврийн контенерууд байгаа.



Зураг №5. Засварын газрын зураг

Төсөл хэрэгжих хугацаа: Зүүн Хөшөөтийн уурхайн төсөл нь ТЭЗҮ-ээр 14 жилийн хугацаанд хэрэгжихээр төлөвлөгдсөн.






Төслийн техник тоног төхөөрөмж: 2023 онд уурхайн жилийн хүчин чадлыг 1.4 сая.тн сайн чанарын цэвэр нүүрс байхаар төлөвлөж байна. Төслийн ашиглалтын ерөнхий технологи нь хөрс хуулалт, олборлолтын ажлыг ил аргаар хийж, алсын тээвэрлэлт хийх зохилготой явагдаж байна. “Төфис майнинг” ХХК нь Зүүн Хөшөөтийн чулуун нүүрсний ордыг “Нормаунт” ХХК, “Пауэр Бласт” ХХК, “Өсөх чимэг эстимейт” ХХКомпаниудтай гэрээний үндсэн дээр хамтран ашиглаж байна.

Ашиглалтын үеийн хайгуулын ажил: Ашиглалтын блокуудад 2023 онуудад ашиглалтын хайгуулын ажлыг гүйцэтгэнэ. Хайгуулын ажлын зорилго нь ордын нөөц өсгөх, нүүрсний давхраасын зүй тогтлыг судлахад оршино. Нийт 10 цооног, 3000 тууш метр, цооногийн дундаж гүн нь 300 тууш метр байхаар төлөвлөж байна.

Ашиглалтын хайгуул (Чанарын нэмэлт судалгаа)-ын цооногуудыг Ил уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсан эхний жилүүдэд уурхай тэлэх, нүүрсний давхраасын зүй тогтлыг бүрэн тогтоох хэмжээнд байна.

Өрмийн нүүрсний 1 дээжийн урт нь 1-3м /нүүрсний исэлдэл, чанарын бүсээс хамаарч/ байх ба тухайн 2м-т агуулагдах нүүрс, нүүрсний дундах 10 см хүртлэх чулуулгийг хамтад нь дээжлэнэ. Нийт 1500 орчим дээж авахаар төлөвлөж байна. 2023 онд 6,816.26 сая.м³ хөрс хуулж, 1579.8 мян.тн сайн чанарын нүүрс 123.73 мян.тн дулааны нүүрс олборлоно. Хөрс хуулалтанд XCMG-XE900D 4ш, нүүрс олборлолтод Doosan-300 6ш ажиллана. Нүүрс болон хөрсний тээвэрлэлтэнд Tonly - автосамосмал 39 ширхэг сонгон авч уулын ажлыг хийхээр төлөвлөв. Уулын ажлын туслах техник бульдозер Shantui - 1 ширхэг ажиллана.

Хүснэгт №2. Уурхайд ажиллаж байгаа машин техникийн мэдээлэл

д/д	Тоног төхөөрөмжийн нэр				Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн он	Тайлбар	Тээврийн хэрэгслийн зураг
	Төрөл	Марк	Загвар	Аль улс				
1	Суудал	Toyota	Land Cruiser 70	Япон	2	2018	Төфис майнинг ХХК	
2	Суудал хагас ачаа	Toyota	Land Cruiser 70	Япон	1	2018	Нормаунт ХХК	
3	Суудал	Toyota	Alphard	Япон	1	2018	Нормаунт ХХК	
4	Өрмийн машин	ECD45E	Jk590C	Хятад	6	2018	Нормаунт ХХК	
5	Эксковатор	Xugong	XE900D	Хятад	2	2018	Нормаунт ХХК	
6	Компрессор	Kaishan	KSCV-580/17	Хятад	6	2019	Нормаунт ХХК	

7	Автосамосвал	Тонгли	875B	Хятад	10	2018	Нормаунт ХХК	
8	Утгуурт ачигч	XCMG	ZL50GV	Хятад	2	2018	Нормаунт ХХК	
9	Усны машин		XDM40	Хятад	1	2018	Нормаунт ХХК	
10	Түлшний машин				1	2018		
11	Авто кредер	Xugong Pingji	GR2403	Хятад	1	2018	Нормаунт ХХК	
12	Бульдозер	Shenwa	SD45H-3	Хятад	1	2018	Нормаунт ХХК	
13	Ачааны	УАЗ		Орос	2	2014	Нормаунт ХХК	
14	Бүхээгтэй	Mitsubishi	HINO	Япон	1	2016	Повер бласт ХХК	
15	Суудлын	Toyota	Ланд крузер 200	Япон	1	2010	Повер бласт ХХК	
16	Суудлын	Toyota	Feilder	Япон	1	2003	"Өсөх чимэг эстимейт" ХХК	

1.5 Ажиллах хүчний тухай мэдээлэл

Уурхай баяр ёслолын өдрүүд, амралтын өдрүүдэд амрахгүйгээр тасралтгүй ажиллахаар төлөвлөв. Уурхай нь бүтэн жилийн турш 7 хоногийн 7 ажлын өдөр, хоногт тус бүр 12 цагаар 2 ээлжээр ажиллана. 14 хоног ажиллаад 14хоног амрах хуваарьтай байх учир 2 багийн ээлжийн ажилчид ажиллана. Төслийн хүрээнд нийт 315 ажилчин ажиллаж.

Хүснэгт №3

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарь хугацаа	хоног	91	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	2	Баяр ёслол, цаг агаарын саатал, засвар үйлчилгээ
4	Жилд ажиллах хоног	хоног	350	
5	Хоногийн ажлын горим		2 ээлж	
6	Ээлжийн хугацаа	цаг	12	
7	Хоногт ногдох ажлын нийт цаг	цаг	24	
8	Жилд ногдох ажлын нийт цаг	цаг	2124	

1.6 Уурхайн нүүрсний химийн лаборатори: Лабораторийн үйл ажиллагааны зорилго бол уурхайн үйлдвэрлэлийн технологийн дамжлага хэвийн үргэлжлэхэд чиглэгдэнэ. Уурхайн болон үйлдвэрлэлийн ажиллагааг жигд хэвийн явуулахад дараах үзүүлэлтүүдийг тогтмол үзэх шаардлагатай. Тухайлбал лабораторид нүүрсний хайгуулын дээж, уурхайгаас зөөвөрлөгдөн ирж буй экспортод гаргах түүхий нүүрс, лабораторийн үйл ажиллагааны зорилго бол уурхайн үйлдвэрлэлийн технологийн дамжлага хэвийн үргэлжлэхэд чиглэгдэнэ. Уурхайн болон үйлдвэрийн ажиллагааг жигд хэвийн явуулахад дараах үзүүлэлтүүдийг аяжигдсан товарын нүүрсэнд тус тус лабораторийн шинжилгээ хийж хяналт явуулдаг.

Уурхайг ашиглахын өмнө хийж баталгаажуулсан лабораторийн шинжилгээний дүнгээс харахад Зүүн Хөшөөтийн уурхайн ордын нүүрс нь чийглэг, хүхэр багатай, үнслэг өндөртэй, дэгдэмхийн бодисын агуулга бага, шатах цулын нүүрстөрөгчийн агуулга 63%- иас дээш байгаа зэргээс үзэхэд нүүрсний ангиллын дагуу коксжих нүүрсэнд хамаарна.

Лабораторийн шинжилгээ суурин лаборатори, уурхайн ажлын талбайд ачааны машинд ачаалах нүүрсний туузан дамжуулагч дээрээс гэсэн 2 янзаар явуулна.



Зураг №6 “Зүүн хөшөөт”-ийн нүүрсний уурхайн химийн лабораторийн гадна болон дотор байдал.

Лабораторид дараах тоног төхөөрөмжүүд ашиглан дээжийн шинжилгээ явуулна.

Лабораторийн багаж тоног төхөөрөмж

Хүснэгт №4

Д/д	Нэр төрөл	Марк	Цахилгааны хэрэглээ	Тоо	Нэгж
1	Сорилт хэмжигч Ажлын температур - 1000	GF-8000	8кВт	1	ш
2	Хүхэрийн хүчил хэмжигч	WDL-9000A	220W 50hz	1	ш
3	Ү - Индекм тодорхойлох (0-999 градус хэмжилт хийнэ)	JC-8	220кВт 50hz	1	ш
4	Индекм тодорхойлох (G-индекс тодорхойлох)	NJ-9	84кВт	1	ш
5	Хлор хэмжигч	FL900	5кВт 220Вт	1	ш
6	Тугалга хэмжигч	CHg-6000	40VA, 220Вт	1	ш
7	Хатаах төхөөрөмж	101-1	3кВт, 220Вт 50hz	1	ш

Багаж

8	Бутлагч (800*500*850mm 6 ширхэг)	GJ-1	220Вт 50hz	1	ш
9	Бутлагч (900x500x850mm)	PC-200x300	2.2кВт, 220Вт 50hz	1	ш
10	Хэмжүүр хэмжилт 100гр	FA1004 RS232 LCD	340x215x350	1	ш
11	Калориметр	ZDHW-9000C		1	ш
12	Шатаах зуух			1	ш
13	Дээж хуваагч			1	ш
14	Нэрмэл Ус нэрэгч	WP-RO-10B		1	ш

Лабораторид дээжүүдийг шинжлэн судлахад дараах 16 нэр төрлийн химийн бодис, материал ашиглана.

Лабораторийн химийн бодисууд

Хүснэгт №5

Д/д	Урвалжийн нэр	Химийн томьёо	Зориулалт
1	Цахиурын оксид	SiO ₂	Нүүрсний фторын шинжилгээ
2	Натрийн гидроксид	NaOH	Нүүрсний фторын шинжилгээ
4	Трисодиум цитрат	C ₈ H ₅ Na ₃ O ₇ ·x2H ₂ O	Нүүрсний фторын шинжилгээ
5	Калийн нитрат	KNO ₃	Нүүрсний фторын шинжилгээ
6	Натрийн фторид	NaF	Нүүрсний фторын шинжилгээ
7	Калийн бромид	KBr	Нүүрсний фторын шинжилгээ
8	Мөнгөний нитрат	AgNO ₃	Нүүрсний фторын шинжилгээ
9	Этанол	C ₂ H ₅ OH	Нүүрсний фторын шинжилгээ
10	Азотын хүчил	HNO ₃	Нүүрсний фторын шинжилгээ
11	Бромокрисол индикатор	C ₂₁ H ₁₄ Br ₄ O ₅ S	Нүүрсний фторын шинжилгээ
12	Шинжилгээний стандарт дээж	GBW	Нүүрсний шинжилгээнүүд
13	Вольфрамьн оксид	WO ₃	Нүүрсний хүхрийн шинжилгээ
14	Устөрөгчийн хэт исэл 30% уусмал	H ₂ O ₂ (AR)	Нүүрсний фторын шинжилгээ
15	Антрацит нүүрс		Барьцалдах чадвар тодорхойлох
16	Бензойны хүчил	C ₆ H ₅ COOH	Илчлэг тодорхойлох

Энд товарын бүтээгдэхүүний техникийн шинж чанарын гол үзүүлэлтүүд болох илчлэг (Qdaf, Kкал/кг), чийглэг (Wад %), үнслэг (A d %), дэгдэмхий бодис (V daf %), хүхэр (S d%), фосфор (P, %)– ийг түүхий тус тус тодорхойлно.

Харин нүүрсний төрөл өөрчлөгдөхөд дээрх үзүүлэлтүүдээс гадна бүрэн техникийн шинжилгээ явуулна.

1.7 Уулын ажлын ерөнхий мэдээлэл:

“Тефис майнинг”ХХК нь Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордын өмнө, зүүн өмнө, зүүн захын хэсгийг хамаарах талбайд нүүрс олборлохоор 2015 оны III сарын 25- ны өдөр Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас MV-018291 ба MV-018293 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан байна. Энэхүү тусгай зөвшөөрөлтэй талбайн нийт хэмжээ 1086.69 га (733.28га, 353.39 га).

Одоогоор “Зүүн Хөшөөтийн уурхай” гэж нэрлээд буй Хөшөөтийн ордын зүүн захын хэсгийг ордын уул геологийн нөхцөл, нүүрсний давхаргын зузаан, унал, сунал, хөрсний зузаан, физик механик шинж чанар зэрэгт үндэслэн 2018 оны 7 сараас эхлэн одоогийн ашиглалтын системээр буюу ил аргаар, экскаватор - автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглаж байна. Ордын нөөц босоо, хөнтрүү байршилтай ба олборлолтын ажил 250м гүн хүртэл үргэлжилнэ. Иймээс уулын ажлын фронт нь нүүрсний давхаргын суналын дагуу чиглэлээр ба гүнзгийрэлт нь нүүрсний уналын дагуу явагдана. Уурхайн ашиглалт эхэлснээс хойш олборлосон нөөц:

- 2018 онд В+С зэргээр 208.32 мян.тн цэвэр нүүрс.
- 2019 онд В+С зэргээр 174.17 мян.тн цэвэр нүүрс.
- 2020 онд ямар нэгэн ашиглалтын ажил хийгдээгүй.
- 2021 онд 1.54 мян.тн цэвэр нүүрс. Ийнхүү “Тефис майнинг” ХХК нь 2018 – 2021 оны хооронд В зэрэглэлээр чулуун үетэй нүүрсний 152.66 мян.тн, цэвэр нүүрсний 143.05 мян.тн, С зэрэглэлээр чулуун үетэй нүүрсний 244.72 мян.тн, цэвэр нүүрсний 240.97 мян.тн буюу нийт В+С зэрэглэлээр чулуун үетэй нүүрс 397.34мян.тн, цэвэр нүүрс 384.03 мян.тн-ийг тус тус олборложээ. Уурхайн ашиглалтын нийт хугацаа 14 жил. Эрчим хүчний нүүрсээ дотоодын зах зээлийн хэрэгцээнд, экспортын нүүрсээ уурхайн ашиглалтын эхний жилүүдэд түүхийгээр, цаашид коксжуулах замаар Хятад улсын аж үйлдвэрийн зах зээлд нийлүүлэхээр төлөвлөжээ.

1.8 2023 оны уулын ажлын төлөвлөлт: 2023 онд “Зүүн Хөшөөт”-ийн уурхайгаас 10.34 сая м³ хөрс хуулж, 2.73 сая тн нүүрс олборлох буюу нийт 12.08 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Сард дунджаар 1.35 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэнэ. Мөн 2.46 сая тн коксжих нүүрс, 0.27 сая тн эрчим хүчний нүүрс олборлоно.

18. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

18.1 Уур амьсгал

Хөшөөтийн нүүрсний орд нь газарзүйн байршлын хувьд Монгол Алтайн уулархаг их мужийн Алтайн мужид хамаарна. Монгол Алтайн нурууны зүүн урьд төгсгөлийн хойт хэсгийн д.т.д 1900- 2250м-ийн өндөршилд баруун болон урьд хэсгээрээ Баатарын нуруу (3475м), Тахилт уул (2650м), урьд хэсгээрээ Салхит уул (2632.6м), Уушигийн хоолойгоор, зүүн, зүүн урьд хэсгээрээ Цаст Богд (4090м), Гоотын нуруу (2373м), хойт талаараа Зэрэг-Дарвийн хоолойгоор тус тус хүрээлэгддэг. Эдгээр уулс нь эгц, гүн хавцлуудаар хэрчигдэж нарийн нийлмэл рельефийг үүсгэжээ. Хөшөөтийн нүүрсний орд нь бараг урьд зүгээс хойшоо, зүүн хойноосоо баруун урьд зүгт шахагдсан антиклиналь атирааны гол тэнхлэгийн дагуу байршилтай юм.

Төслийн талбай, түүний ойр хавьд жилийн хамгийн дулаан VII сард агаарын температур Зэрэгт +21.5°C, Цэцэгт +17.2°C, Дарвид +20.4°C ба харин хамгийн хүйтэн I сард Зэрэгт -24.8°C, Дарвид -22.9°C, Цэцэгт -24.6°C хүйтэн. Энэ бүс нутагт чийгийн хангаамж, хур тунадас харьцангуй бага, уулсын ар өвөр хөндий, тал газартаа жилдээ (83.3- 118.0mm), тухайлбал Дарвид 118мм, Зэрэг 83.3 мм, Цэцэгт 62.2 мм хур тунадас унана.

Чийг хангамжийн үзүүлэлт далайн түвшнээс 1500м- ээс нам газартаа 0.1- 0.2 буюу нэн хуурай дулаан бүсэд тус тус хамаарна. Төслийн бүс нутаг бол манай орны хамгийн салхи ихтэй газар нутгийн нэг бөгөөд жилийн дундаж салхины хурд 1-2 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 3.0-3.4м/с. Хөндийдээ байнгын салхи ажиглагдана. Энд салхины хамгийн их хурд 8.0- 24.0м/с хүрдэг. Төслийн бүс нутагт жилийн дундаж байдлаар баруун-баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч орон нутгийн салхи тод илэрнэ.

18.2 Гоморфологи

“Зүүн Хөшөөт”-ийн нүүрсний орд нь Монгол Алтайн уулархаг их мужийн Алтайн мужид хамаардаг. Монгол Алтайн нурууны зүүн урд төгсгөлийн хойт хэсэгт далайн түвшнээс дээш 1900-2250м өндөрт оршдог Баруун болон урд хэсгээрээ Баатарын нуруу (3475 м), Тахилт уул (2650 м), зүүн болон зүүн урд хэсгээрээ Цаст Богд (4090 м), Гоотын нуруу (2373 м), хойд талаараа Зэрэг-Дарвийн хоолойгоор, урд хэсгээрээ Салхит уул (2632.6 м), Уушигийн хоолойгоор, хүрээлэгддэг.

Эдгээр уулс нь эгц, гүн хавцлуудаар хэрчигдэж нарийн нийлмэл рельефийг үүсгэжээ. Хөшөөтийн нүүрсний орд нь зүүн хойноосоо баруун урд зүгт шахагдсан антиклиналь атирааны гол тэнхлэг дагуу байршилтай юм.

18.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Төслийн талбайн орчмын нутаг нь ус зүйн хувьд төв азийн гадгаш урсгалгүй ай савд багтдаг. Энэ хавьд байгаа томоохон гол нь сутай хайрханы баруун хойд бэлээс эх авч талбайн араар зүүн уридаас хойш чиглэн урсах хөшөөт гол, түүний баруун зүүн талын цутгал болон булаг, горихууд бөгөөд нуураас хамгийн том ын талбайн баруун урдуур. Баатарын нурууны өмнө бэл хөндийд байрлалтай Цэцэг нуур, уулсын ар хөндийд хөшөөт голын харалдаа орших Дарвийн цагаан нуур болно.

2.4 Усан хангамж;

Тус төслийн талбайд зам усалгааны ажлыг Байгаль орчны сайдын А-301 тоот дугаартай тушаалаар батлагдсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын дагуу 1м² талбайд 2л ус зарцуулна. 2023 оны уулын ажлын хүрээнд 80,173.5м² талбайтай зам болон ногоон байгууламж, бусад жилийн 05 дугаар сараас 11 дүгээр сарын 01 хооронд нийт 215 хоног усалгааны ажил хийгдэнэ. Нийт 40,247.0 м³/жил ус шаардагдана. Өөрийн гүний худгаас болон уурхайн шүүрлийн усаар хангахаар төлөвлөж байна.

Ус ашиглалтын төлбөрийг Цэцэг нуур Хүйсийн говь сав газраас 2019 онд гаргасан ус ашиглалтын дүгнэлтээр 1м³ усны төлбөрийг зохих аргачлалын дагуу 188.16 төгрөгөөр тооцсон.

Уурхайн ажилчдын ундны усыг зөөврийн цэвэр усаар хангаж, хэрэглээний усыг өөрийн гүний худгаас хангаж байна. Төслийн унд-ахуйн усны хэмжээг Байгаль орчны сайдын А-301 тоот дугаартай тушаалаар батлагдсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын дагуу 1 хүн хоногт 150л

ус хэрэглэнэ гэж авч үзэв. Иймээс 140 хүнтэй уурхайн суурингийн унд ахуйн хэрэглээнд жилд 7665.0 м³/жил ус шаардагдана.

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа эхэлж байгаа тул 2023 онд ашиглалтын хайгуул хийгдэхээр төлөвлөгдөөд байгаа бөгөөд энд хэрэглэх унд ахуй болон уурхайн үйлдвэрлэлийн хэрэглээний усыг өөрийн гүний худгаас болон уурхайн шүүрлийн усаар хангахаар төлөвлөж байна.

Ашиглалтын хайгуулын 2023 оны 3 дугаар улиралд явуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд 2015 оны 07 сарын 30-ны өдрийн Байгаль орчны сайдын А-301 тоот дугаартай тушаалаар батлагдсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын дагуу 100 т.м өрөмдлөгт 10м³ ус зарцуулна. Энэ төрлийн ажилд ашиглах усны хэмжээ нийт 1200 м³/жил байхаар төлөвлөсөн.

Хүснэгт №6. Нийт усны хэрэглээний тооцоо.

		хэмжих нэгж	1 дэх жил
1	Өрөмдлөгийн ажлын усны хэрэглээ	мян.м ³	1.200
2	Унд-ахуйн усны хэрэгцээ	мян.м ³	7.665
3	Зам усалгаа, ногоон байгууламж	мян.м ³	39.047
4	Нийт усны хэрэглээ	мян.м ³	47.919

Нийт унд ахуйн болон технологийн усанд 47,919.0 м³/жил ус хэрэглэхээр тооцогдсон байна.

2.5 Хөрс

Сутай уулсийн баруун том салбаруудын нэг зүүн өмнөөс баруун хойш хөшөөт голын голдрилийг даган түүний урдуур үргэлжилэх уулсын ерөнхийдөө ургаш баруун ургаш, баруун чигт амины хөтөлрүү налуувтар хотгор гүдгэрийн ялгаа ихтэй энгэр газраар Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар монгол алтайн хөрсний тойргийн өндөр уулын босоо бүслүүрийн хагас хуурай хэв шинжид хамаарагддаг өндөр уулын нугат хээрийн өндөр уулын хээрийн болон уул хээрийн хөрс зонхилон тарахдаг.

Монгол алтай нурууны хөрс бүрэлдэн тогтох үйл явцад газрын хотгор, гүдгэр, ар, өвөр, хажуугийн тогтоц уур амьсгал тодорхой нөлөөлж хөрсний босоо бүслүүр үүссэн байдаг. Хөрсний судалгаа явуулсан хөшөөтийн нүүрсний уурхай зүүг өмнөд болон өмнөд талын залгаа нутаг нь сутай хайрханы самбар болох хөшөөт уулаас (3158.8) м баруун хойш уурхайн төв хүртэл аажим намсан үргэлжилдэг уулархаг хотгор гүдгэртэй болхоор энд өндөршил гадаргуугийн хэрчигдэл хажуугийн налуу хөрс үүсэгсэн чулуулгын илрэх гүн, ялзмаг хуримтлалын давхаргаас хамаарч хүрэн хөрсний төрөлүүд болох уулын хар хүрэн, сайргархаг хар хүрэн нимгэн ялзмагт давхрагтай хүрэн бай сайрын сул хөрстэй мөн гадаргын урсац ул хөрсний усны тэжээлтэй холбоотой тогтворжсон хагас чийгт болон чийгт гарлын нугын цэвдэгт хөрс тус тус тархдаг.

2.6 Ургамлан бүрхэвч

“Зүүн Хөшөөт”-ийн уурхай орчмын нутаг болон Баатар хайрханы нуруу нь урагмал газарзүйн хувьд Монгол алтайн уулын хээрийн тойрогт хамаарах бөгөөд Дорнод монголын тойргийн Сутай, Баатар хайрханы районд хамаарах бөгөөд уулийн бүслүүрийн сарьдаг тагийн дэд бүслүүр, ойн бүслүүр, өндөр уул хээрийн бүс, хуурай хээрийн, цөлжүү хээрийн, цөлийн хээрийн зэрэг дэд бүслүүр илэрнэ. Хөшөөтийн уурхайн “Тэфис майнинг” ХХК-ийн талбайн ойр орчмын ургамлын аймаг нийт 20-н овог 47 төрөл 56 зүйл цоргот дээд ургамал бүртгэгдсэн. Эдгээр нь амьдралын хэлбэрийн

сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөгөнцөр, олон наст өвслөг, цөөн наст өвслөг гэсэн хэлбэрт хуваагдах бөгөөд олон наст өвслөг урагмал зонхилох хувийг эзэлнэ.

2.7 Нийгэм, эдийн засаг

Хүн ам: Энэ нутагт халх ба захчингууд голлон амьдарна. Хүн амын нягтшил багатай, нутгийнхны гол эрхэлдэг ажил нь мал аж ахуй юм. Ярант болон Бургастайн хилийн боомтоор худалдаа наймаа хийж өөрсдийн хэрэгцээг хангадаг. Дарви сумын төвд 128 өрхийн 600 орчим хүн амьдардаг. Дийлэнх нь мал аж ахуй эрхлэх бөгөөд 5% орчим нь худалдаа арилжаа хийхээс жижиг хоолны газрууд ажиллуулдаг байна.

Дарви сум 5 багтай, баруун бүсийн өндөр хүчдэлийн шугамтай холбогдсон, хүн эмнэлэг, мал эмнэлэг, холбооны салбар, 11 жилийн дунд сургууль, ШТС, үүрэн телефоны G Mobile, MobiCom, Unitel-н сүлжээтэй юм.

Дэд бүтэц: Ховд аймаг нь Монгол орны өрнөд мужийн төв хэсэгт 76.0 мян.км² газар нутгийг эзлэн оршдог. Ховд аймаг баруун хойт, хэсгээрээ Баян-Өлгий, Увс аймаг, зүүн хойд хэсгээрээ Завхан, зүүн хэсгээрээ Говь-Алтай аймагтай, өмнөд, баруун өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэн оршдог. Дэд бүтэц, аж үйлдвэр сул хөгжсөн. Харин Дарви сум нь Улаанбаатар-Ховд-Баянөлгий чиглэлийн төв зам дагуу түүний хойт талаар байрших ба энд хэд хэдэн ШТС, томоохон замын үйлчилгээний төвтэй тул зорчигчид зоогийн газар, худалдаа үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлж алжаалаа тайлах, машин тэргэндээ жижиг үйлчилгээ хийж, ШТС- уудаар үйлчлүүлдэг.

Цахилгаан эрчим хүчний хангамж: Баруун Монголын ЦДС нь ОХУ-тай холбогдон эрчим хүчээр хангагддаг. Ховд аймгийн Дарви, Зэрэг, Цэцэг ба Мөст сумууд Манхан сумын 110 кВ-ын дэд станцтай 35 кВ-ийн шугамаар холбогдсон. Энэ сүлжээнд 12МВт-ын хүчин чадалтай Дөргөнийн усан цахилгаан станц холбогдсоноор Баруун Монголын ЦДС-ний найдвартай ажиллагаа сайжирч ОХУ-аас эрчим хүчний хамаарал багасах сайн талтай боловч өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах боломжгүй хэвээр байна.

19. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирлагыг тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргав.

19.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт №7. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт №8. Эрсдэлийн зэрэглэлийн түвшин, тэдгээрийн удирдлагын арга хэмжээ тайлбар

Түвшин	Ангилал	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ
L	Бараг эрсдэтэй I	Эрсдэл нь зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур бөгөөд ердийн үйл ажиллагааны журмаар зохицуулах.
M	Дунд зэрэг II	Эрсдэл нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнд бөгөөд байнгын хяналт тавих ба шийдэл нь тодорхой байх шаардлагатай.
H	Их эрсдэлтэй III	Эрсдэл нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн ба байгууллагаас анхаарч идэвхтэй арга хэмжээ авах шаардлагатай
E	Маш их эрсдэлтэй IV	Эрсдэл нь зөвшөөрөгдөх дэд хэмжээнээс маш их хэтэрсэн ба нэн даруй анхаарал хандуулах шуурхай арга хэмжээ авах шаардлагатай, энд байгууллагын дээд удирдлага, БОАЖЯ, УУХҮЯ-ны байгаль орчин, уул уурхайн хяналт, онцгой байдлын байгууллагаас анхаарч онцгой арга хэмжээ авах шаардлагатай.

Хүснэгт №9. Тохиолдох магдлалын шалгуур үзүүлэлтүүд

Зэрэглэл	Уршиг	Магдлалын тодорхойлолт		Уршиг	Уршигийг бууруулах арилгах шийдэл
		Хүн, мал, амьтан	Эд хөрөнгө		
I	Бараг болохгүй	Гэмтэлд өртөхгүй	Хохиролд өртөхгүй	Ялимгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Магад болохгүй	Гэмтэл анхны тусламжаар эдгэрнэ	Хохиролд багавтар өртөнө	Бага	Газар дээр нь шийдэх шаардлагатай
III	Болзошгүй	Эмнэлэгийн тусламж авах шаардлагатай	Хохиролд дунд зэрэг өртөнө	Дунд	Газар дээр нь шийдэх, гадны тусламж авах шаардлагатай
IV	Магад болох	Хүн гэмтэл авч хөдөлмөрийн чадвараа алдана	Их хохиролд өртөнө	Их	Газар дээр нь шийдэх
V	Лавтай болох	Амь нас эрсдэнэ	Маш их хохиролд өртөнө	Гамшиг	Газар дээр нь шийдэх

20. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр Зүүн Хөшөөтийн нүүрсний уурхайг ил аргаар олборлох үед байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, энэ нөлөөллийг бууруулах, арилгах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль хамгаалах арга хэмжээг тухайн цаг үеийн шаардлага, зорилт, зорилготой нийцүүлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн салшгүй бүрдэл хэсэг бол байгаль орчны менежментийн төлөвлөгөө мөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнүүд нь тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тусгагдав.

Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явц, түүний үр дүнг хянах зорилгоор Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана. Энэ ажлыг жил бүр мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт 2023 онд төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тусгав.

“Тефис майнинг” ХХК нь уурхайн ашиглалтынхаа 2023-онд хугацаанд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон гол ба болшгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нутаг дэвсгэрийн тухай хэсэгт бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, сааруулах талаар санал болгож буй зөвлөмжийг “Тефис майнинг” ХХК нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлж ажиллах юм. БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлагаа мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор бууруулж, байгаль орчныг хамгаалж, байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах, сайжруулах зорилтыг хангах үүднээс тэнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;
- Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага нэг бүрт мөрдөх технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Болзошгүй аваар ослын үед авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг цаг үеийн хэрэгцээ шаардлагын дагуу байнга шинэчлэх шаардлагатай бөгөөд энэ нь аливаа нэгэн ослын үед (зөрчлийн тухай мэдэгдэж тайлагнах, шалгах дэг журам, урьдчилан сэргийлэх ба залруулах арга хэмжээ) мөрдөгдөхөөр байх;
- Уурхайн ашиглалт, түүний ирээдүйн явц байдлаас байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нарийвчлан тусгасан байх;

- Ил уурхайн аюулгүйн зон-хамгаалалтын бүсийн дэг журам, түүнд учирч болох газар ашиглалттай холбоотой бэрхшээлүүд, байгалийн нөхцөл, ойр орчмын суурьшил, бэлчээр ашиглалтаас төслийн үйл ажиллагаанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүний хэтийн төлөв;
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулсан зааварчилгаа өгөх;
- Байгаль орчны менежментийн талаар БОННУ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;

Төслийн хэрэгжилтийн явцыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай нийцүүлэн явуулахын тулд түүнийг хариуцсан байгаль орчны 2-3 мэргэжилтэн ажиллуулах, агаар, хөрс-ургамал, гадаргын /Хөшөөт гол дээр/ ба гүний усны хяналтын цэгүүд тогтоож тохижуулах, суурин болон хөдөлгөөнт багаж төхөөрөмжүүдээр явуулах хэмжилтийг тогтмолжуулах талаар төлөвлөгөөнд тусгасан болно. Иймд байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн хэрэгжилтийн хугацаанд түүний салшгүй нэг хэсэг төдийгүй уурхайн үйлдвэрлэлийн нэгж хэсгүүд дээр технологийн хэвийн жигд ажиллагааг хангахад байгаль орчны талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл нь болж өгнө. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, БОАЖ-ын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, БОНХСайдын 2014 оны 04-р сарын 04-ний өдрийн А-117 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулав.

БОМТ нь байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах болон гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай буюу нөөц нэмэгдүүлэх хайгуул судалгаа, төсөл хэрэгжүүлэх хугацаа, техник технологийн шинэчлэлт өөрчлөлт болон жил бүр хэрэгжүүлж буй орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй дүгнэлтүүдтэй уялдаж байх шаардлагатай.

21. БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ

Төслийн бэлтгэл ажил, ордыг нээж ашиглалт явуулах эхний 5 жилд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу жил бүр хийх арга хэмжээнүүдийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд нарийвчлан гаргахдаа уул геологийн нөхцлийн онцлог, ордын нөөцийн хэмжээ, ашиглалтын хугацаа, ажлын эрчим, олборлох технологи, тэнд ашиглагдах уулын машин механизм, тээврийн хэрэгсэл зэргийг харгалзан үзэж, тооцоолсон болно.

“Төфис майнинг” ХХК нь төслийн ТЭЗҮ-ийн тайландаа байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг аль болох бууруулахаар амьдрал дээр хэрэгжүүлэх боломжит ерөнхий зорилтуудыг тавьсан байгаа бөгөөд түүний биелэлтийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жил бүр хийхээр заасан байгаль хамгаалал, гол ба

болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, цаашлаад арилгах болон нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлуудын хэрэгжилт, үр дүн харуулах юм.

Уурхайн ашиглалтын үед байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг компанийн захирлын удирдлага дор уурхайн байгаль орчны мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар нүүрсний уурхайн үйлдвэрлэлийн технологийн нэгж хэсгүүдэд үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэйгээр, сөрөг нөлөө багатай хэрэгжүүлэх бүрэн бололцоотой юм.

Төсөл хэрэгжүүлэгчээс ойрын 5 жилийн хугацаанд төслийн нөөц нэмэгдүүлэх хайгуулын үр дүн, технологи шинэчлэлт, өргөтгөлтэй холбоотой өөрчлөлт хийх бүртээ холбогдох төрийн яаманд төслөө танилцуулж, БОННУ болон БОМТ-д өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэрлүүлж байх, нөгөө талаар аймаг, орон нутгийн байгаль орчны албадад Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар тайлангаа жил бүр 11-р сарын 15-ны дотор тайлагнана.

Зүүн Хөшөөтийн уурхайг ашигласнаар Монгол улсын эдийн үасаг, нийгмийн амьдалд тодорхой хувь нэмэр оруулах нь дамжиггүй, харин цаашид ашиглалтын хугацаандаа хүнд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогыг цаг ямагт баримтлан ажиллах шаардлагатай. Энд

- Хуулийг чанд мөрдсөн
- Байгаль орчны хамгаалсан
- Хүний хөгжлийг хөхүүлэн дэмжсэн
- Эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн
- Нийгмийн эмзэг бүлэгт анхаарал хандуулсан
- Байгаль цагуурын хүндрэлүүдийг эрсдэлгүй даван туулахад нутаг усныханд тусалж дэмждэг
- Соёл уламжлалыг хүндэтгэсэн
- Иргэдийн оролцоог дэмжсэн, хамтарч ажилладаг
- Ирээдүйд учрах хор уршгийг тооцож, урьдчилан сэргийлсэн
- Ил тод, нээлттэй бодлого, стратеги, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Төслийн БОННУ ба Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь энэ бодлогод тулгуурлан боловсруулагдсан гэдгийг анхаарахад илүүдэхгүй.

22. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус компани нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн эрсдлийг бууруулах талаар байнгын хяналт тавин ажиллахын зэрэгцээ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулан түүний дагуу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь байгаль орчны чиг үүргийг тодорхойлж байгаа бодлогын хэрэгжилтийн нэг хэсэг юм.

6.1. УДИРДЛАГА , ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №10

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан	Баримтдах стандарт, дүрэм журам
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх, тус ажлыг хариуцах мэргэжилтнүүд бүхий нэгж байгуулах	500,000	2023 оны II улирлаас үл хэтрүүлэх	“Тефис майнинг” ХХК	Байгаль орчны хуулийн эмхэтгэл, холбогдох дүрэм журам, стандартууд
2	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалаас	2023 онд 1 удаа	“Тефис майнинг” ХХК	
3	Гэнэтийн осол (гал түймэр, үер, салхи шуурга, хөрсний гулсалт, нуралт, газар хөдлөлт, аянга цахилгаан гэх мэт) гарсан тохиолдолд, мөн тэсрэх бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг нийт ажилчдад танилцуулах, мөрдөж ажиллах;	1,500, 000	2023 онд	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, хөдөлмөр хамгаалал-аюулгүй ажиллагааны мэргэжилтэн	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар
4	Уурхайн ажиллагсдыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт тогтмол хамруулах;	Эрүүл мэндийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу төлбөрт	Уурхайн ашиглалтын хугацаанд жил бүр	“Тефис майнинг” ХХК, уурхайн удирдлага эмч	ЭМ-ийн Сайдын 2014 оны 10-р сарын 20-ны өдрийн 340 дугаар тушаал, Эрүүл мэндийн урдчилсан болон хугацаат үзлэгийн журам
5	Дарвийн Мөрөн багийн энэ хавьд хамгийн ойр оршин суудаг айл өрхүүдтэй байнгын холбоотой байж, тэдний санал зөвлөмжийг авах, тэдний нийгмийн асуудалд тулгарч буй зарим хүндрэлүүдээ шийдвэрлэхэд /өвс тэжээл бэлтгэх, унаа хөсөг шаардлагатай/ нь зарим зүйл дээр хамтарч ажиллах;	-	2000,000 2023 онд	“Тефис майнинг” ХХК, Уурхайн удирдлага	Орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулах юмуу сайн дурын үндсэн дээр
6	Байгаль орчны талаар зохиогдож байгаа улс, аймаг орон нутгийн чанартай сургалт семинарт урилгын дагуу байгаль орчны мэргэжилтнийг оролцуулж байх;	1000,000	2023-онд тухай бүрт	“Тефис майнинг” ХХК,	
7	“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” хэрэгжүүлэх ажлаар Агаар,Ус.Хөрсний шинжилгээг тогтмол хийж үр дүнг хэлэлцэх.	3,000,000	2023 он жил бүр	Гэрээт мэргэжлийн байгууллага	
Нийт зардал					8,500,000

23. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэг №11

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан хамгаалах ба бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгж зардал (мян. төг)	Нийт зардал (мян. төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт аргачлал	
7.1. АГААРЫН ЧАНАРЫГ ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ							
Уурхайн хөрс хуулалт, тэсэлгээ, ухлага малталт, нүүрс олборлолт. тээвэрлэлтийн үеийн орчны агаарт тархах хөрс шороо, нүүрсний тоос, хортой хий, утаа тортог	Тээврийн хэрэгслийн тохиргоо үйлчилгээг байнга хийж, машины яндангаас гарах утааны хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгана. Машин, механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр, талбайд хийж гүйцэтгэнэ.	Экскватор, бульдозер, өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл, бусад	800,000	Хуваарьт үзлэг-үйлчилгээ	2023-он	Агаарын тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хуулиуд, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.	
	Тоосжилт бууруулах зорилгоор уурхайн технологийн зам болон уурхай хотхон хоорондын замын усалгаа арчилгааг үйл ажиллагаа эхэлсэнээс хойш тогтмол хийж, зорчиж буй авто машинд хурдны хяналт тавих.	Уурхайн малталт, тээвэрлэлт, гадаад дотоод зам овоолго, нүүрсний агуулахууд			Ажлын хөлс	2023- он жил бүрийн 05 сараас 1сар хүртэл	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019
	Жил бүр ОХШХ- ийн хөтөлбөрийн хүрээнд заасан хуваарийн дагуу агаар дахь тоос, бохирдолын хэмжээ, хяналт шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж, зөвлөмжийн дагуу бохирдлыг бууруулах, арга хэмжээг авч ажиллана.	Тоос, хортой хий, дуу чимээг бууруулах		Тухайн жилд 2-3 удаа хийх	ОХШХ- өөр 1000,000	Жил бүр Дулаан улиралд	MNS 4585:2007 Төрөл бүрийн ажлын орчин дахь дуу шуугианы хязгаарлалтууд, 2007.04.30 Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий

						шаардлага. MNS 5002-2000
	Салхи шуурга ихтэй хавар намрын улиралд уурхайн зам талбайд ус шуршиж тоосролтыг бууруулах Шороон замаар явах хурдны хязгаар тогтоох (Ажлын талбайд очих замд <40 км/ц, Ажлын талбай дотор <30 км/ц) тэмдэгжүүлэх арга хэмжээ авах	Уурхайн дотоод замын сүлжээ, овоолгын аж ахуй, нүүрсний агуулах	жилийн 5 сараас 11сарын хооронд	200,000	2023- он Жилийн дулаан улиралд 05,11 сар	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585-2016
	Алсын замд нүүрс тээвэрлэлт хийж буй машинуудыг тэвшний бүтээлгээр бүрэн хангаж, ашиглалтад нь хяналт тавих, цаг хугацаанд нь шинэчлэх сайжруулах арга хэмжээ авч байх;	Нүүрсний бүх машинууд	250-н машин	Жилийн төсөвт тусгагдах	2023- он	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585-2016
	Шатахууны агуулах дахь нөөцлүүрүүдийн амьсгалах хоолойн хэвийн ажиллагаанд хяналт тавих эргэн тойронд галаас хамгаалах даланг хийх /энд өвс ургамал, хог цэвэрлэх ажлыг тогтмолжуулах/ 50м- ээс багагүй зурвасаар татах,	Шатахууны агуулахын зүүн өмнө, өмнө талаар	200,000		2023 он Нэг удаа	
АГААРЫН ЧАНАРЫГ ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗАРДАЛ. МЯН.ТӨГ				2,000,000		
7.2. ХӨРСИЙГ ЭЛЭГДЭЛ, ЭВДРЭЛ, БОХИРДЛООС ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ						
Шимт хөрс хуулагдаж зайлуулагдах, хөрс эвдрэх, газрын хэвлийд хоосон орон зай бий болох, хөрс газар овоолгод дарагдах, хөрс элэгдэж сулрах, эвдрэх	уурхайн авто замын дэд бүтэцийг арчилж тордох, гадны хүчин зүйлийн нөлөөллийг сааруулах Уурхайн замын зорчих зурвасыг өргөсөхөөс хамгаалах арга хэмжээ авах; Ачилт хийлгэхээр хүлээх нүүрсний машинуудад байршлын нь зөв оновчилсон, хүчин чадлын хувьд тохирсон автозогсоол гаргах	Замын зурвас дагуу түүний 2 талаар үргэлжлэх хөвөөг засч нягтруулан /2.7 км, машин давж гарах боломжгүй/ өндөрлөж, хамгаалалтын арга хэмжээ авч сайжруулах;		300.000	2023 онд	Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага. MNS 3998:1990
		Нүүрс тээврийн машин байрших боломжтой авто зогсоол байгуулах;		1 000.000	2023-онд	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008.
	Эрүүл газарт хөрс хуулах, овоолго байгуулах бүрт талбайн үржил	Шимт хөрс Овоолгын ажлын			700.000	2023 оноос жил бүр

	шимтэй хөрсийг хуулан шимт хөрсний овоолгод хадгалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд эргүүлж ашиглах зорилгоор овоолго үүсгэж, механик өгөршлөөс хамгаалах	талбай				хууль: Зүйл 25-2; Газрын тухай хууль: Зүйл 50-1.1,1.2; 55-2, 3,4,5
	Уурхайн замын сүлжээний ашиглалтад тавих хяналтыг тогтмолжуулах, суларсан, эвдэрсэн хэсгүүдийг хусч тэгшлэх, дүүргэж нягтруулах зэргээр засч тордох, цэвэрлэх ажлыг тухай бүр нь бүрэн хийж байх;	Уурхайн дотоод замын сүлжээний эвдэрсэн хэсгүүд	Өдөр тутам хийвэл зохих арчлалт	2023-оноос		Хөрс хамгаалах, цөлжилтээс сэргийлэн тухай хууль, ил уурхайн автотээврийн аюулгүй ажиллагааны дүрэм,
ХӨРСИЙГ ЭЛЭГДЭЛ ЭВДРЭЛ, БОХИРДЛООС ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ . МЯН.ТӨГ				2,000,000		
7.3 УРГАМАЛ НӨМРӨГИЙГ ТАЛХАГДЛААС ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ						
Ургамал шимт хөрсний хамт хуулагдаж зайлуулагдах, хөрс шороонд дарагдах, ургамлын есөлт хөгжил доройтох, бүрхэц буурах, зүйл өөрчлөгдөх, хөл ургамал түрж орж ирэх, машин зам мөрөөр хөрс ургамалгүй болтлоо цулгүйрч нүцгэрэх, хөрс сулрах	Ажилчдын тосгоны орчны тоосжилт их босдог газруудад тогтмол усалгаа хийэ чийглэж, норгох, газруудад зорчих авто машины хурдыг 10 км цаг байхаар өгнө талбайг услаж, дагтаршаагүй зам дээр явах машины хурдыг хязгаарлана,	Талхлагдсан, халцарсан бохирдсон газрууд	Жилд 0.5 га	250,000	2023- он. Жил бүр	
	Уурхайн суурингийн чөлөөт талбайд ногоон байгууламж байгуулах	Кемпийн хашаанд		1,300,000	2023 он нэг удаа	
	Хөрсний сулралт үүсч тоосжилт үүсгэхээс сэргийлэх кемпын хашааны гадана болон дотон авто зогсоолийг стандартын дагуу хучилт хийж тэмдэг тэмдгэлэгээ байршуулна.	Кемп хашаа дотон гадна		450,000	2023 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ургамлын тухай хууль
УРГАМАЛ НӨМРӨГИЙГ ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗАРДАЛ. МЯН.ТӨГ				2,000,000		

7.4 ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ ГОРИМ, НӨӨЦ, ЧАНАРЫГ ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ						
Ус бохирдох, гүний усны түвшин буурч нөөц багасах, бохирдох, гадаргын ба гүний усны гидроластик холбоо, түүний байгалийн тэнцвэр алдагдах, уурхайд орж ирэх шүүрлийн усны алдагдал нэмэгдэх, голын усны урсац багасч цаашид хуурай голдирол үлдэх	Уурхайн баруун хойт захад шүүрлийн усыг ашиглан хийсэн цөөрмийн эргэн тойронд мал амьтан унаж эрсдэхээс хамгаалж овоолсон шороог засаж тэгшлэн хайслах, ус соруулж авах хэсгийг налуулалт хийж тохижуулах, тэмдэгшүүлэх арга хэмж авах;	Цөөрмийн эргэн тойронд	-	650,000	2023 он	Усны тухай хууль, MNS4596:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”
	Шингэн, тослох материал асгарсан үед гүний ус болон хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж, асгаралт үүссэн талбайн бохирдсон хөрсийг цэвэрлэх арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулна	Тусгай зөвшөөрөлтэй талбай		550,000	Тухай бүр	
	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт хийнэ.	“Тэфис майнинг” ХХК-ийн уурхайн эзэмшлийн худгууд		350,000	Жилийн турш	
	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх, уурхайн усны хэрэглээг зорилтод түвшинд байлгах, зүй зохистой ашиглах.	Уурхайн хэмжээнд		Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Усны тухай хууль
	Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлж барагдуулах.	Уурхайн хэмжээнд		Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Ус бохирдуулсны тухай хууль
	Орой хяраараа нүүрс олборлолт явагдаж буй уулнаас Хөшөөт гол руу буух хуурай сайр жалга дагуу нүүрс бусад хог цэвэрлэх ажлыг тогтмолжуулж,;	Уулнаас Хөшөөт гол руу буусан томоохон 2 сайр-жалга.	-	450,000	2023- он жил бүр	
	Үйлдвэрлэлийн зориулалттай ашиглалтын гүний худаг гаргах			Гэрээгээр	2023 онд	MNS 5918:2008 Усан орчны чанарын үзүүлэлт
	ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ ЧАНАР, НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ. МЯН.ТӨГ			2,000,000		

7.5 АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ						
	Уурхайн ажлын бүсийг хязгаарлах, дуу чимээ, тоосыг хамгийн доод түвшинд байлгах, хог хаягдалгүй цэвэр орчин бүрдүүлж ажиллах байгаль хамгааллын арга хэмжээнүүдийг урьдчилан авч хэрэгжүүлсэн байх, энд байгаль орчны хяналтыг тогтмолжуулах;	Хяналтын үр дүнг харгалзан тухай бүр нь авч хэрэгжүүлэх нэмэлт арга хэмжээ	--"	500,000	2023- он.	Амьтны тухай хууль 6 дугаар зүйл, 6.1.3, 6.1.7, 6.1.9
	Уурхайн олборлолтын явцад эртний амьтан ургамлын үлдэц, яс (палеонтологийн) болон археологийн холбогдолтой бусад үнэт ховор олдвор гарч болохыг илэрсэн тухайд хамгаалалтад авч, мэргэжлийн байгууллагад мэдэгдэх;	Уурхайн захиргаа	"-	300,000	уурхайн ашиглалтын хугацаанд	Амьтны тухай хууль, 37 ба 39 дүгээр зүйл. Хохирол нөхөн төлүүлэх тухай, торгууль
	Нүүрсний замын мал сүргийн зөрөг зам дайран өнгөрч байгаа хэсгүүдэд жолооч нарт хурдаа сааруулах, зогсоход анхааруулсан замын тэмдэгүүд байрлуулах, засаж сайжруулж байх;	Хуучныг сайжруулах, байршлыг тогтоож шинээр хийх		400,000	2023-он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль
	Нөлөөллийн бүсийн Цэцэг Дарив сумдын байгаль орчны тасагын үйл ажилгаанд тусгагдсан зэрлэг ан амьтан хамгаалах биотехникийн хамтран оролцоно.	Байгаль орчны мэргэжилтэн	"-	800,000	2023-он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль
АН АМЬТНЫГ ХАМГААЛАХ ЗАРДАЛ. МЯН.ТӨГ				2,000,000		
Сөрөг нөлөөллийг бууруудах арга хэмжээний нийт зардал					10,000,000	

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний зорилго оршино. Хүний амьдрах орчин, эрүүл мэндэд учруулах хог хаягдлын сөрөг нөлөөг илрүүлэн зохих арга хэмжээ авахад хэрэглээ, бүтээгдэхүүний сонголтыг харгалздаг дэлхий нийтийн хандлага бий болж байгаад анхаарна.

Энэхүү хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь “Тэфис майнинг” ХХК-ийн төслийн бүхий л үйл ажиллагаанаас гарч буй бүх төрлийн хог хаягдалд хамаарна.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг энэхүү төслийн талбай дээр үйл ажиллагаа явуулж буй үндсэн болон гэрээт байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй

Хүснэгт №12

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нүүрсний уурхайн ашиглалт									
9.6.1.	Уурхайн суурингийн ахуйн хог	Хатуу шингэн	<ul style="list-style-type: none"> - Бүх төрлийн ахуйн хатуу хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилан ялгах, хаягдлын зөөврийн савнуудыг төрөлжүүлэн байршуулах, - Хогийг тухайн савны багтаамжийн 2/3- оос ихгүй дүүрэх үед орон нутгаас зөвшөөрөл бүхий нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн буулгах Уурхайн суурин дахь уурын зуухнаас гарч буй үнсийг таг хавхлага бүхий тусгай зориулалтын саванд түр хийх - Уурын зуухны түлшинд ашиглаж буй түүхий нүүрсийг хийх битүүмжлэл сайтай агуулах барьж ашиглах - Уурын зуухны эргэн тойрны орчныг бүрэн цэвэрлэж, нүүрс буулгах, зуух цэнэглэх талбайг хатуу хучилт хийж сайжруулах, - Үнсийг зөвшөөрөл бүхий хогийн 	Бохир ус цэвэрлэх байгууламжид цэвэрлэн байгальд хаях	-	500 кг/хон	1200.00	2023- онд	<ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын тухай хууль - Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011 - Хог хаягдлын ангилан ялгалтын зааварчилгаа - Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 - Агаар бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх агууламж MNS 5885:2008

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг						
2	9.6.2	цэгт хүргэн нүхэнд хийж дарж булах, мөн зам, барилгын материалд ашиглах боломжийг хайх, нийлүүлэхэд анхаарах;													
		- ЦБ-ийн технологийн дамжлагуудад хийх үзлэг-үйлчилгээ, засварыг тогтмолжуулж, хэвийн ажиллаж байх нөхцөлийг ханган ажиллах;									200.00		200.000	2023- оноос жилд 4 удаа	
		- Уурхайн суурин дахь ЦБ, шингэн хаягдлын цооног, хогийн цэг, түүний орчимд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ариутгал цэвэрлэгээг тогтмолжуулж, ялаа шавж үржихээс хамгаалах								Цэвэрлэх байгууламж		170.00		500.000	2023- он Жил бүр
		- Уурхайн шатахууны агуулах, , засварын газар дахь нефтийн бүтээгдэхүүний гаралтай хатуу шингэн хогийг хийх зориулалтын савуудтай байх	Түр хийх савууд	ширхэг	110.00	50кг/хон	400.000		Хог хаягдлын тухай Хууль						
		- Асгарсан шатах тослох материал ба машин механизмын эд ангийг цэвэрлэх, шингээж авах хатуу шингэн бодис материалыг нөөцтэй байх;	Бэлэн байдлыг хангах	кг	60.00		400.000		-						
		- Нефтийн бүтээгдэхүүний гаралтай хатуу шингэн хогийг нэгдсэн "хогийн цэгийн тусгай зөвшөөрөл бүхий хаяг адресстай тусгаарлагч бүхий нүх ухмалд хийж дарж булах	Аюултай хог шийдвэрлэлт	Сав баглаа			300.000		-						
НИЙТ, МЯН.ТӨГ								3000.000							

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №13

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Хөрс хуулалт, ухлага малталт, нүүрс олборлолт тээвэрлэлтийн үеийн ХХАА-ны дүрэм журам зөрчигдөх	Ажиллагсдыг ХХАА-ны хувцас хэрэгсэл, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Бүх ажилчид	Төслийн төлөвлөлтөнд тусгах		Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 он - Гамшгаас хамгаалах тухай хууль, - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан зөвлөмж БД 12-106-14 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй байдал. Хамгаалах газардуулга, тэлэлт MNS 5146:2002 - Засгийн газрын 2006 оны 149-р тогтоолын 2-р хавсралт, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм	
2		Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажил эхлэхээс өмнө ХХАА-ны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХХАА-ны зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох		-	-	Өдөр бүр		
3		ХХАА-ны зааварчилгаа, ажиллагсдад аюулгүй ажиллагааны дүрэм журам, аливаа болзошгүй эрсдэлээс хамгаалах, ослын үед өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх талаар танхимын ба үзүүлэх сургалтуудыг төрөлжүүлэн зохион байгуулах;		400.00	8 000.00	2023- 2027 онуудад улирад 1 удаа		
4		Бүх техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, газардуулга хийх	Зохион байгуулах	Төслийн төлөвлөлтөнд тусгах		Бэлтгэл ба ашиглалтын шатанд		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
5		Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга заав-рыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг ажлын талбаруудын аль тохиромжтой газар байрлуулах				Төсөл хэрэгжих бүх хугацаанд		
6		Том хэмжээний болзошгүй аваар ослын үед хэрэглэгдэх хөөс, абсорбент, хамгаалах маск, шүүлтүүр, хүчилтөрөгчтэй баллон зэргийг хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх;						
8	Өдөр бүр ажил эхлэхийн өмнө тээврийн хэрэгсэл, машин механизмын бүрэн бүтэн байдалд үзлэг хяналт явуулж, тээвэрлэлт хийх, зам талбайд ажиллах зөвшөөрөл өгч байх		500, 000		2023- он			
9	Галын аюул	Уурхайн тосгоны барилга байгууламжийг гал унтраах багаж хэрэгслээр холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангах, шаардлагатай газруудад байрлуулах (гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт)	80 м ² ихгүй талбайд тус бүр 1 ш галын хор байршуулах	1. 500.000		Уурхайн ашиглалтын үе	- Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94 - Гал гарах үед анхааруулгын самбар, объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566:2005	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
11		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Зохион байгуулах		400, 000	Улиралд 1 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, Шатахуун түгээх станцын галын аюулгүйн норм БНБД 21-01-14
12	Байгалийн гамшигт үзэгдэл	Цаг агаарын аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээллийг үндэслэн урьдчилсан арга хэмжээ авах	Зохион байгуулах, төлөвлөх	600, 000		Уурхайн ашиглалтын үед	-
		Аянга зайлуулагчийг тооцоолсон өндөршилд байрлуулах					Аянга зайлуулагчийг суурилуулах стандарт, норм дүрэм
НИЙТ. МЯН.ТӨГ						3 000.000	

10. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ойр орчмын газрын хэв шинж, үзэмж, төрхийг доройтуулах нөхцөл байдал бүхий эвдрэл ихтэй газарт нөхөн сэргээлтийг түрүүлж хийхээр зураг төсөлд тусгаж хэрэгжүүлж ажиллана. Нөхөн сэргээлтийг менежментийн төлөвлөгөөний дагуу уурхайн олборлолтын үйл явцтай зэрэгцүүлэн хийж, түүний жилийн ажлын хэмжээг олборлолттой уялдуулан зохистой харьцааг барьж ашиглалт явуулна.

Нөхөн сэргээлтийн төлөв	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛУУЫН ТӨЛӨВЛӨГӨӨ						
Хоёр. Ургамлын нөхөн сэргээлт						
	Ургамлын нөхөн сэргээлт	Машин тэрэг, хүний үйл ажиллагаагаар багаас дунд зэрэгт талхлагдсан (25-50%) газруудыг ялгаж талбайг хайслан хөл хөдөлгөөнөөс хамгаалах, зам харгуйг хааж тэмдэгшүүлэн ургамал нөмрөг байгалийн аясаар нөхөгдөх нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авах (хайгуулын үед элэгдэж талхлагдсан 0.5 га);		1,500.00		
	Техникийн нөхөн сэргээлт	2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн ажил тусгагдаагүй болно.				MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
	Биологийн нөхөн сэргээлт	Үржил шимт хөрсийг 25 см ээс баггүй зузаантай хуулж овоолгыг нэмэгдүүлэх , хашаалах, хадгалах		1,500.00		
НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ. МЯН.ТӨГ				30000 00		

11. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ховд аймгийн Дарви сумын нутагт орших MV-018291, MV-018293 дугаартай ашигт малтмалын хайгуулын талбайд түүх, археологийн дурсгалуудыг археологийн судалгааны орчин үеийн арга зүйн дагуу нарийвчилсан хайгуулыг гүйцэтгэсэн боловч ямар нэгэн түүх, археологийн дурсгал илэрч мэдэгдээгүй байна. Түүх, археологийн дурсгал дайрагдсан өртөгдсөн эсэхэд нарийвчилсан шалгалт хийсэн бөгөөд энэхүү уулын малталтанд ямарваа нэгэн түүх, археологийн дурсгал өртөгдөөгүй болно. Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүх соёлын дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой үүргээ биелүүлэн ажиллана.

12. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч компаниас хийж буй биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажил нь уул уурхайн компанийн зүгээс ордын ерөнхий байршил, уул-геологийн нөхцлийн онцлогоос шалтгаалж, жил бүр нөхөн сэргээлт хийгээд байх боломжгүй юмуу цаашид уурхайн хаалтын нөхөн сэргээлтээр төслийн талбай байгалийн төрхдөө ойртож сэргээгдэх боломжгүй нөхцөлд орон нутгийн саналыг харгалзан байгалийн нөхцөл ижил төстэй газруудад хийж гүйцэтгэнэ.

Энэ удаа дүйцүүлэн хамгаалах ажлыг Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа нэн түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлс хийх, бууруулах, нөхөн сэргээх сум орон нутгаас ирүүлсэн ажлын санал хүсэлтийг үндэслэн дүйцүүлэн хамгаалах арга замаар хийгдэнэ.

Байршил: Ховд аймгийн Дарви сум.
Цэцэг сум.

Хүснэгт №15

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгж ширхэг	Хэрэгжүүлэх хугцаа	Нийт зардал сая.т	Баримтлах стандарт аргачлал
Булгийн эхийг хашиж хамгаалах	Сум орон нутгаас тогтоож өгсөн газарт булгийн эхийг хашиж хамгаалах	Дарив сум	1ш	2023-он 3 –р улиралд	50.0	MNS5918:2008
Булгийн эхийг хашиж хамгаалах	Сум орон нутгаас тогтоож өгсөн газарт булгийн эхийг хашиж хамгаалах	Цэцэг сум	1ш	2023-он 3-р улиралд	50.0	
Усан орчинг сайжруулах	Тодорхойлсон газарт гүний худаг гаргах	Дарви сум	1ш	2023-он 3-р улиралд	20.00	
Усан орчинг сайжруулах	Тодорхойлсон газарт гүний худаг гаргах	Цэцэг сум	1ш	2023-он 3-р улиралд	20.00	
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ НИЙТ ЗАРДАЛ. МЯН.ТӨГ			2023	50,000.000	50.00	

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт №16

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд ба байршил	Хугацаа ба давтамж	Нийт зардал. мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
АГААРЫН ЧАНАР			
<p>А. Уурхай, түүний үйлдвэрлэлийн баазын ажлын бүс, ойр орчмын агаар дахь хортой хийн агууламж</p> <p>Хянах зүйл: уурхайн ажлын бүс, бусад агаар бохирдуулах байгууламжуудын дэргэд</p> <ul style="list-style-type: none"> Түлшний дутуу шаталтаар агаарт хаягдал хортой хий NO₂, CO, SO₂, CO₂ Нефтийн бүтээгдэхүүний ууршилтаар агаарт хаягдах хортой хий (HnCm, H₂S, SO_x, CO, N_{ox}, бенз-а-пирен) <p>Хяналтын цэгүүд: Энэ цэгүүдийг ажлын бүсэд урьдчилж тогтоосон байна. Үүнд: Уулын машин механизмын ажиллагаа /ухах, түрж бөөгнүүлэх, ачих/ 1 цэг</p> <ul style="list-style-type: none"> Уурхайн дотоод тээвэрлэлт /уурхай- овоолгын хооронд/ 1 цэг Зөөврийн ШТС 1 цэг <p style="text-align: right;">Нийт 3 цэгт</p> <p><u>Үргэлжлэх хугацаа:</u> (30 минутын үнэлэмжээр нэг цэгт 1 удаа)</p> <p><u>Хяналтын давтагдалт:</u> Жилд 2-3 удаа</p>	Үйл ажиллагааны явцад жилд 2-3 удаа	1.350.00	MNS 4585-1998 MNS-0012-013:1991 MNS 5365:2004
ХӨРСӨН БҮРХЭВЧ			
<p>А. Хөрсний химийн шинж</p> <p>Хянах зүйл: Ялзмаг, хөдөлгөөнт элемент /кали, фосфор, азот/, урвалын орчин</p> <p>Эдэлбэр талбайн хэмжээнд:</p> <ul style="list-style-type: none"> Зөөврийн ШТС- ын түгээх талбайн орчимд 1 цэгт Авто зогсоолын орчимд 1 цэгт <p><u>Үргэлжлэх хугацаа:</u> минутын үнэлэмжээр нэг цэгт 1</p> <p>Хяналтын давтагдалт: Жилд 2-3 удаа</p> <p style="text-align: right;">Нийт: 2 цэг</p>	Үйл ажиллагааны явцад жилд 2-3 удаа	500.00	MNS 4918:2000 MNS 4919:2000
ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ ГОРИМ, ЧАНАР, НӨӨЦ			
<p>Унд ахуйн усны чанар</p> <p>Хянах зүйл: Усанд орчин рН, эрдэсжилт, хатуулаг, азотот нэгдэл, ариун чанар</p> <p>Хяналтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> Уурхайн суурингийн унд ахуйн хэрэгцээнд ашиглаж буй усанд Уурхайн шүүрлийн ус 1 дээж Уурхайн ажлын бүсээс гадагш газрын хэвгийн дагуу зүүн урагш, урагш байршилтай уст цэг /шинээр байгуулах/ 1 цэгт/ <p><u>Үргэлжлэх хугацаа:</u> 40-50 минутын үнэлэмжээр нэг цэгт 1</p> <p>Хяналтын давтагдалт: Жилд 2-3 удаа</p> <p style="text-align: right;">Нийт: 3 цэгт</p>	Үйл ажиллагааны явцад жилд 2-3 удаа	1,200000	MNS 17.5.15- 92 MNS4429:1997 MNS4430:1997 MNS 0900: 1992 MNS 3935:1986 MNS 0900: 2008 MNS 4943:198 MNS5628:2008 MNS5631:2008

ГАЗРЫН ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГАА			
А: Төслийн талбайн хөрсний чанарын хянан баталгаа, газар ашиглалт Хянах зүйл: Хөрсний чанарын хянан баталгаа гаргуулж зураглал хийлгэх Хяналтын давтагдал: 5 жилд 1 удаа Хяналтын цэгүүд: Төслийн талбай түүний ойр орчмын 3 км-ийн радиуст	Үйл ажиллагааны явцад 5 жилд 1удаа	Гэрээгээр	MNS 331-91 MNS 2305- 94 MNS3263- 90
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ЗАРДАЛ (МЯН.ТӨГ)		3000,000	

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсаны дараа төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх ба түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор БОАЖСайдын А-618 тушаалын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймгийн Байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Тайланг газар дээр нь хянаж дүгнэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах ба ажлын хэсэг нь БОМТ-ний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн оноогоор дүгнэнэ. Ажлын хэсэг нь БОГ-ын уул уурхайн байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, газар ашиглалтын мэргэжилтэн, тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч, багийн Засаг дарга, багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, нөлөөллийн бүсэд оршин сууж буй айл өрх, иргэдийн төлөөлөл, байгаль орчны ТББ-ын төлөөллүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУВААРЬ

Хүснэгт №17

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1.	Байгаль орчны асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллага /БОАЖЯ/	Тухайн жилийн БОМТ-г хүргүүлэх, батлуулах	2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	БОННУ батлагдсанаас хойш 1 сарын дотор	-Тефис майнинг” ХХК, ерөнхий геологич, уулын инженер	УБ хот, БОАЖЯ-ны байр
2.	Сум багийн удирдлага, Иргэдийн Нийтийн Хурлын төлөөлөгч, нутгийн иргэд, малчид	БОМТ- ий дагуу жил бүр хэрэгжүүлэх ажлуудын талаар аман мэдээлэл хийх	Тухайн жилийн БОМТ-ний дагуу хийгдэх байгаль хамгаалал, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлууд болон нийгмийн амьдралын дээшлүүлэх талаар товч танилцуулга хийх	2023 жил бүр,	Тефис майнинг” ХХК- ийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд	Сум, багийн Иргэдийн Нийтийн хурлын танхимд
3	Уурхайн нөлөөллийн бүс дэх нутгийн иргэд малчид зэрэг олон нийтийн төлөөлөл, ТББ- ууд	- Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газрын талаар -Орон нутгийн газар ашиглалтын талаар -Нүүрс олборлолттой холбоотой хууль эрхзүйн орчны талаар	Тусгай хөтөлбөрийн дагуу уурхайн үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл хийх, ойлголтыг зөрүүг арилгах, хууль эрхзүй, уурхайн үйлдвэрлэлийн технологийн талаар соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	2023-онд жил бүр	Зүүн Хөшөөтийн уурхай дахь “Тефис майнинг” ХХК- ийн төлөөлөл, байгаль орчны мэргэжилтнүүд	-Сум, багийн Иргэдийн Нийтийн хурлын танхимд
	Аймгийн Байгаль орчны газар	БОМТ- ий тухайн жилийн биелэлт, үр дүн Тухайн жилийн БОМТ-г биелүүлэхэд орон нутгийн захиргаа, ард иргэдийн оролцоо, үр дүнгийн талаар Дараа жилд БОМТ-нд шинээр авч үзэх ард иргэдээс дэвшүүлж буй гол асуудлуудын талаар	БОМТ- ийн хэрэгжилтийн үр дүнгийн талаар мэдээлэл хийх Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах,	2023-онд жил бүр	Зүүн Хөшөөтийн уурхай дахь “Тефис майнинг” ХХК- ийн төлөөлөл, байгаль орчны мэргэжилтнүүд	-Сум, багийн Иргэдийн Нийтийн хурлын танхимд
5.	захиргааны төв байгууллага- БОАЖЯ Байгаль орчны асуудал хариуцсан Төрийн	Компани, уурхайн удирдлага, орон нутгийн төлөөллийн дүгнэлт бүхий тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хүргүүлэх	Тухайн жилд хийж гүйцэтгэсэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт нөхөн сэргээлтийн ажил,	Жил бүрийн 12-р сард багтаан	Уурхайн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд	УБ хот, БОАЖЯ-ны байр

15. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

Хүснэгт №18

№	Төлөвлөгөөнүүд	Төсөв сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	10,000.000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөөгийн зардал	3.500.000
3	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	50,000.000
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээн ажлын зардал	1,500.000
5	Удирдлага зохион байгуулалтын зардал	8,500.000
6	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний зардал	3,000.000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3,000.000
8	Осол эрсдэлийн менежментийн зардал	3,000.000
Нийт		82,500,000

“Тетфис Майнинг” ХХК-ийн “Зүүн хөшөөт” нүүрсний уурхайн 2023-оны БОМТөлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийхэд дээрхи хүснэгтэнд заасны дагуу нийт **82,500,000.0** сая.төг зарцуулахаар төлөвлөлөө.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг зүүн хөшөөт нүүрсний ордын ТЭЗҮ, БОНБУ, уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн боловсрууллаа.

Бид уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу гүйцэтгэх болно.

16. НЭМЭЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Ховд аймгийн Дарви сумын нутагт байрлах Зүүн хөшөөтийн нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг “Тефис майнинг” ххк нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих хөдөлгөөнд нэгдэн 30,000ш мод тарихаар шийдвэрлэн зардлыг тусгав. Нэг модны өртөг 14850 төг болохоор байна.

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн хүрээнд 30.000ш мод тарих төсвийн тооцоолол

Хүснэгт №19

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэгж	Нэгжийн үнэ	Зардал
1	Мод худалдан авах	ш	30,000.0	2,000.0	60,000,000.0
2	Цалингын зардал	Хүн	10.0	10,150,000.0	101,500,000.0
3	Шатахуун	л	33,442.6	3,050.0	102,000,000.0
4	Хүнс	Хүн өдөр	25.0	1,020,000.0	25,500,000.0
5	Ажилчидын байр	Сар хоног	4.0	11,000,000	44,000,000.0
6	Тээвэр	Тээвэр			52,000,000.0
7	Багаж хэрэгсэл				37,550,000.0
8	Бусад зардал				22,850,000.0
	Нийт				445,400,000.0

ХАВСРАЛТУУД